

“Мод”-той холбоотой зүйрлэхүүн ба утгын өгүүлэмж

Чулууны Бямбацэцг^{ORCID}

Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургуулийн Монгол хэлний тэнхимийн багш, доктор (Ph.D), Улаанбаатар, Монгол Улс

Хүлээн авсан - Received:
2024-10-24

Засварласан - Revised:
2024-11-28

Хэвлэгдсэн - Published:
2024-12-30

byambatsetseg@msue.edu.mn
ORCID: [0009-0005-0615-2579](https://orcid.org/0009-0005-0615-2579)



© 2024, Author(s)

Хураангуй: Энэхүү өгүүлэлд монгол хэлний хэвшмэл хэллэгт багтах аман зохиолын жижиг төрөл оньсого, хүүрнэн өгүүлэх аман зохиолын төрөл болох явган үлгэрээс “мод” хэмээх зүйрлэлээр илэрч буй ухагдахууныг хэл, соёл, утга зүйн талаас нь авч үзэж байна. Монгол хэлэн дэх хэлц үг хэллэгт аливаа ард түмний соёл, үндэсний сэтгэлгээ, зан заншил, газар нутгийн байршил, ахуй амьдралын онцлог гэх мэт угсаатны өвөрмөц онцлогийг өөртөө агуулсан байдгаас гадна ихэнх нь юм үзэгдлийг шууд ба шууд бусаар заан нэрлэдэг онцлогтой юм. Иймд “мод” хэмээх зүйрлэлээр илэрч буй ухагдахууныг орон ба утгын хүрээнд задлан тайлбарлахыг зорив.

Түлхүүр үг: цаг хугацааг зүйрлэх, амьтныг зүйрлэх, бичгийн хэрэгсэл, эд юмс, эд эрхтний нэр, утга зүй, орны ай

УДИРТГАЛ

Хэлнээс ангид орших юм үзэгдэл, шинж чанар, үйл байдлыг хэлний илэрхийллээр орлуулан тэмдэглэх арга, зүй тогтлыг тодорхойлох нь хэлний тогтвортой нэгжүүдийн утгын мөн чанарыг тайлах үндэс болох юм.

Хэлний нэгжийн утга бол хийсвэрлэн сэтгэх үйл ажиллагааны явц, үр дүнгийн илэрхийлэл болдгийн дээр сэтгэцийн олон янзын үйлдэл утгад бас хамаатай юм. Аливаа нэг юм, үзэгдлийн шинжийг нөгөө юм, үзэгдлийн төстэй шинжтэй жишиж дүрслэх тархины үйл хөдөлгөөн хэлний зүйрлэлээр илрэн гарах нь бий.

П.Эрдэнэтуяа “Тухайн ард түмний танин мэдэхүйн бүхий л туршлага, шашин-гүн ухаан, зан суртахуун, ёс зүй, уран сайхан, гоо зүйн төсөөлөл болон зарчмууд хэлээр илрэх нь бий. Иймээс хэл бол угсаатан соёлын үйл ажиллагааны тулгуур элемент болж, тухайн үндэстэн, угсаатны нийгмийн ухамсар, уламжлал ба соёлыг хадгалах, илэрхийлэх, нэвтрүүлэн дамжуулах арга хэрэглүүр болдог” (Эрдэнэтуяа.П., 2022) гэж тодорхойлсон байна.

Иймээс бид хэлний баримт болох тогтвортой нэгж болсон хэлц хэллэг, аман хийгээд бичгийн хэлнээ зүйрлэл элбэг байгааг хэлний баримтаас олонтоо үзэж болно.

Ж.Төмөрцэрэн “... Хэлний зүйрлэл бол толь бичигт тэмдэглэгдэх бөгөөд уран зохиолын зүйрлэл бол толь бичигт орохгүй” (Төмөрцэрэн.Ж., 2001, хууд. 31) хэмээн бичсэнээс ухааж үзвэл хэлний зүйрлэлийг аман зохиолын эх сурвалжаас, утга зүйн нэгжээс нь танин мэдэж, тодруулах нь зүйтэй юм.

Утга зүйн орон гэдэг бол утга санааны тодорхой нэгэн бүсэд багтах, зүйл хуваасан үг, хэллэг, хэлцийн утгын сүлбээ хүрээг шинжилсэн ухагдахуун юм. Утга зүйн орны тухай өрнө, дорнын хэл шинжлэлийн бүтээлүүдэд тэмдэглэсэнээр ирснийг тоймлон авч үзвэл: Оросын хэл шинжээч М.М. Покровский “Үгс шүтэн барилдах зарчим хэмээн нэрлэж байсан бол, Германы хэл

шинжээч И.Трир 1920-30-аад оны үед “оюун билиг” гэх утга санааг илэрхийлж байгаа үүр үгийг түүн аваад, утга зүйн нэгэн оронд багтаан авч үзэж судалсан бол мөн Германы эрдэмтэн В.Порциг “Өгүүлбэрийн орон” хэмээх онолын хүрээнд авч үзсэн байдаг. Оросын судлаач Ю.П.Апресян толь бичигт утга санааны ойролцоо байдлаар үгсийг нэгтгэн толгойлсон байдаг, бодит байдлын нэгэн хэсгийг агуулж байдаг, утга зүйн орны нэгэн орны үгс нөгөө үгсээс шалтгаалдаг ажээ. БНХАУ-ын эрдэмтэн Д.Цэцэн утга зүйн орны талаарх ойлголтыг “утгын талбай” гэж нэрлээд “утгын талбай гэж үгийн утгын талаар төрөл харьяат харьцаа бүхий үгс цугларч бүрэлдсэн аймаглалын цогц гэж тайлбарлажээ. Өөрөөр хэлбэл, адил нэг утгын талбайд багтах үгс нь утгын талаар нягт холбогдон, нийтлэг утгын онцлог бүхий нэгэн ерөнхий нэрийтгэл буюу ерөнхий төрлийн дор харьяалагдана” гэсэн үзэл онолоос харж болно.

Д.Бадамдорж “Орчин цагийн монгол хэлний утга судлалын үндэс” хэмээх бүтээлдээ : “Утга зүйн орон нь нэг талаас бодит байдлыг тусгасан, нөгөө талаас хэлний нэгжийн тэмдэглэж байгаа ухагдахууны ямар нэгэн нийтлэгт үндэслэсэн, утгаараа өөр хоорондоо ерөнхий төрөл үүр үглэврүүдээс бүрэлдэнэ. Монгол хэлний үгийн сангийн нэгжийн утга зүйн орон хамгийн ерөнхий байдлаар тэнгэрийн зүйл, шим ертөнцийн зүйл, сав ертөнцийн зүйл, үйл хөдлөлийн зүйл гэж ухагдахууны багтаамж, хүрээгээр нь ангилан авч үзжээ. (Бадамдорж.Д., 1997, хуудсд. 28-29)

Үгийн сангийн нэгжийг утга зүйн орноор нь бүлэглэх уламжлалт оролдлого монгол туургатны толь зүйн түүхэнд нэлээд эртнээс уламжлалтай юм. “Хааны бичсэн манж монгол үгийн толь” (1717), Судар бичгийн хүрээлэнгийн гишүүн Бат-Очир, Мишиг нарын бичсэн “Гучин зургаат тайлбар толь”, Бээжин хотноо хэвлэгдсэн Монгол утгын зүйл хуваасан толь бичиг(1956)-т үгсийг утгын орноор нь сонгон авч, зүйл хувааж, толь зохиожээ.

Л.Цэрэнчимэд “Буриад аялгууны “Тооһорхохо” хэмээх хэлц үгийн утга, соёлын онцлог” хэмээх өгүүлэлдээ “...аль нэг хэлц үгийн утга, бүтэц, хэлбэр хэлний нэгжийн аль түвшинд харьяалагдахаас тайлбарлах зүйлийн хүрээ хязгаар харилцан адилгүй байж болно. “Тооһорхохо” хэлц нь үгийн сангийн үндсэн утга өргөжиж, утга шилжиж бүтсэн хэлц үг мөн” (Цэрэнчимэд.Л., 2024, хуудсд. 23-31) гэж хэлц үгийг угсаатны соёл, сэтгэлгээний онцлог талаас нь өргөн хүрээнд авч үзэж тайлбарласан нь бий.

Энэхүү хэлц үгийн нэгэн адил хэлний тогтвортой нэгж болсон оньсого дахь “мод” хэмээх зүйрлэлээр илэрч буй утга зүйн орны айг авч үзэхэд дараах өвөрмөц шинж оршиж байна.

1. Цаг хугацааг зүйрлэх утга
2. Амьтныг зүйрлэх утга
3. Бичгийн хэрэгслийг зүйрлэх утга
4. Эд юмыг зүйрлэх утга
5. Эд эрхтний нэрийг зүйрлэх утгын хүрээнд илэрч байна.

Модтой холбоотой зүйрлэхүүнийг утга зүйн орны хүрээнээс авч үзвэл мөчир, салаа, навч гэсэн зүйрлэхүүн бүхий оньсого нь жил, сар, улирал, хоног, өдөр, шөнө гэх мэт цаг хугацааг заан нэрлэх орны утгатай байна.

Агар зандан мод

Арван хоёр салаатай

Арван хоёр салаа нь

Гуч, гучин навчтай [жил, сар, хоног]

Агар зандан мод

Арван хоёр мөчиртэй

Мөчир бүр нь гучин навчтай

Навчны дээд тал нь шар

Доод тал нь хар [жил, сар, өдөр, шөнө]

Давах гурван даваа

Зүтгэх гурван шил

Ээрэм гурван тал

Жимст гурван мод [жилийн дөрвөн улирал]

Жил хэмээх цаг хугацааг заасан үгийг агар зандан модоор; модны салаа, мөчрөөр, сар, өдөр, хоногийг; модны навчаар өдөр, шөнийг тус тус зүйрлэсэн байна. Агар буюу зандан мод гэдэг нь халуун оронд ургадаг анхилам үнэртэй хатуу чанарын мод юм. Мод нь мөчир, салаа, навчтай. Жилийн дөрвөн улирлыг оньсоголохдоо *давах*, *зүтгэх*, *ээрэм*, *жимст* гэсэн зүйрлэхүүнээр нэрлэсэн байна. Хүнд хэцүү үеийг даваа давах гэж хэлдэг бөгөөд энэ нь өвөл цагийг, *шил* гэсэн зүйрлэхүүнээр хүн амьтны хүзүүний арын дагуу байдаг шөрмөс, бүлх, мөн түүний орчны газрыг хэлэх бөгөөд өвлийн хахир хүйтэн үргэлжилсэн хүнд хэцүү давааг зүтгэж барж, урин хавартай золгох цагийг, *тал* гэсэн зүйрлэхүүн нь уул даваа, хотгор гүдгэр зэрэг өндрийн хэлбэлзэл бага, эзгүй хээр талыг *зун* цагаар, *мод* гэсэн зүйрлэхүүнээр үр жимс боловсрох цагийг тус тус бэлгэдэн зүйрлэж дөрвөн улирлын тухай оньсогод монгол орны цаг улирлын байдлыг *давах*, *зүтгэх* гэсэн үйл үгсээр даваанаас-шил, шилээс-тал үргэлжлэх орон зайн шилжсэн утгаас босоо харьцааны утгын хүрээнд оньсоголсон байна.

Модны шинж чанар заасан зүйрлэхүүнээс амьтны нэр, тухайн амьтны шинж чанар, онцлогийг танин мэдэх боломжтой байна. Тухайлбал:

Ясгүй бие

Яргүй мод [могой]

Гацуур модыг

Хагалж явлаа

Хамниган үүг

Гүйцэж ядлаа [загас, ус]

Монгол газрын молтогчин

Модон дээгүүр дүүлэгчин [хэрэм]

Тэнгэрийн хүү дүүлэмсэг

Тэр модонд тээглэмсэг [хэрэм]

Мод хэмээх зүйрлэхүүнээр *могой*, *хэрэм* гэсэн амьтныг зүйрлэснийг ажиглахад могойн гаднах биеийг *яргүй модоор* зүйрлэсэн нь өөгүй тэгш гэсэн шинж чанарын утгатай байна. Загасыг *гацуур* мод гэсэн зүйрлэхүүнээр зүйрлэсэн байна. *Гацуур* мод гэсэн үгийг монгол хэлний тайлбар тольд *аливаа модны нарийн салаа мөчир, модны мөчир* гэж үзсэн нь нарийн салаа мөчрийг сүхээр хагалж цуулах, усан дотор орших загасыг гүйцэх, барих хэцүү болохыг модны шинж чанар заасан үгсээр ийн зүйрлэж оньсоголсон бол *модон дээгүүр, доогуур* гэсэн хөдлөх орон байр заасан зүйрлэхүүн бүхий үгсээр, хүний айд хамаарал бүхий *-чин, -мсэг* гэсэн бүтээврээр хүншүүллийн аргаар оньсоголсон байна.

Модны төрөл зүйлийн нэршил бүхий зүйрлэхүүнээр их төлөв бүтсэн эдээр нь бийр бэх, бичгийн хэрэгслийг зүйрлэсэн нь цаад мөн чанартаа бийр, харандааг модоор хийж бүтээдэгтэй холбоотой юм. Тухайлбал:

Хан уулын хад

Хангай газрын мод

Согоо булгын цөс [янтай, бийр, бэх]

Хар хонио төхөөрнө

Хайв тогоонд чанана

Үзүүртэй модоор чичнэ

Үгтэй хэлтэй иднэ [бэх зуурч бийрээр бичих]

Урт хар хүн

Модон дээлтэй

Будган хэлтэй [харандаа]

Үзүүртэй модоор чичих, модон дээлтэй гэж бийр буюу харандааг тус тус хүншүүлэн зүйрлэжээ. Ийнхүү бичгийн хэрэгслийн зүйрлэхүүн бүхий оньсогод хүншүүллийн аргаар оньсоголсон нь бичих, хийх эзэн нь ямагт хүн байхтай холбоотой юм.

Монгол оньсогод модны зүйрлэхүүнээр модоор хийсэн эд юмсын нэршил бүхий сам, шүүр, үс самнах зэрэг хийх үйлийн шилжсэн зүйрлэл бүхий оньсого цөөнгүй байна. Энэ нь *гэдгэр мод, заг мод, уг мод, тайган мод, хавтгай мод, бургас мод* гэсэн модны хэлбэр дүрс, шинж чанар заасан үгсийг зүйрлэхүүн болгон оньсоголжээ. Тухайлбал:

Гэрийн хойно гэгээчин

Гэдгэр мод бариачин [сам, шүүр]

Заг модон заадас гэнэ

Загасан ясан хэлхдэс гэнэ

Уг модны үндэс гэнэ

Өнчин хулсны хэлтэс гэнэ [модон сам, шүүр]

Тайган мод тахим чацуу

Ойн мод онц чацуу [модон сам]

Хүний эд эрхтний нэр болох шүд, нүд, сормуус, гарын хурууг мод хэмээх зүйрлэхүүнээр бүтээжээ. Тухайлбал:

Ардайн модны

Арав нь дээшээ

Арав нь доошоо [шүд]

Армаг тармаг модны цаана

Алаг морьтой эргүүл явна [нүд]

Далайн захад

Зулзаган модод [сормуус]

Ойн мод

Урттай богинотой [гарын хуруу]

Аравгар сарвагар модонд

Алтан эмээл тохоостой [бөгжтэй хуруу]

Ацтай модонд

Алтан эмээл тохox [бэлзэг зүүх]

Эдгээр оньсого дахь *ардай, армаг, тармаг, аравгар, сарвагар* зэрэг дүр байдал дүрслэх үгсээр *шүд, нүд, сормуусыг*, юмны хоёр тийш гарсан салааг ац гэж нэрлэж буй шинжээр нь хүний хурууг тус тус модны мөчир салаагаар зүйрлэж, эд эрхтний нэрийг тус тус оньсоглогосны дээр хуруундаа *эмээл тохox* гэж бөгжтэй хурууг монгол ахуй амьдралтай холбож зүйрлэжээ.

Мод хэмээх зүйрлэхүүнийг хэрэгсэл болгож, хонь төхөөрөөд гэдэс чанах үесдээ *зайдас, хошиного, ходоод*, мөн айргийн *хэхүүр, айраг бүлэх* зэрэг монгол ахуй соёлын уламжлалт хоол хүнсний нэршлийг ч модоор зүйрлэсэн зүйрлэхүүн цөөнгүй тохиолдох нь бий.

Ацат модонд

Алаг ямбийчир [өлгөсөн зайдас]

Модон дотор

Могой тавина [унинд хошиного хавчуулах]

Гарах аман дээр

Ганцхан мод [ходоодны сүлбээр]

Монтгор өвгөн

Модон жинстэй [цус цутгасан ходоод]

Ганц мод найга найга

Газар тэнгэр нир нир [айраг бүлэх]

Хүрэгч үнээ хүндрэг

Ийнхүү мод гэсэн зүйрлэхүүн бүхий хэлний баримтыг ажиглахад цаг хугацаа, лусын амьтад, бичгийн хэрэгслийн нэрс, модоор бүтсэн эд юмс, эд эрхтнээс хөдөлгөөнт эрхтнийг зүйрлэсэн явдал ажиглагдаж буй нь модны шинж болох бүдүүн, хатуу, иш, үндэс, салаа, мөчир гэсэн орны утгын хүрээнээс, шинж чанар, дүр байдал заасан үгсийн хүрээнд зүйрлэсэн 50 гаруй оньсогоос үзэж болно.

Дээрх хэлний баримтаас гадна хүүрнэн өгүүлэх аман зохиолын төрөл болох явган үлгэрт “мод”-той холбогдох өгүүлэмжийн утгыг шидэт үлгэрт байнга давтагдаад байгаа үйл явдлын өрнөлийн хүрээнээс тодруулах оролдлого хийж үзэхэд дараах утгын хүрээнд зүйлчлэн авч үзэх боломжтой юм.

Явган үлгэрт хүүхдийн дүрийг модны мөчир бургасыг дүрслэл болгон ашиглаж, дүрийн орчинг тодорхойлон дүрсэлж иржээ. Профессор С.Дулам “Дүрийн эртний хэлбэрүүд үүссэн нь” хэмээх өгүүлэлдээ “модны мөчир саваа нь яваандаа эртний хүний эр зориг, авхаалж самбааны шалгуур болон сум, жад болон хувирахад амьтай, амьгүй бүх юмыг харваж устгаж болох хүчит мэргэн сумын тухай, тэр сумын эрхий мэргэн харваачийн тухай олон домог үүсгэхэд хүргэсэн бололтой байна.” (Дулам.С., 1989) гэж өгүүлснээс үүдээд мэргэн харвадаг онч мэргэн сум нь хүүхдийн хувь заяаг шийдвэрлэх дүрслэл болон шилжиж буйг явган үлгэрт дүрслэн үзүүлжээ.

Хэн нэгэн ядуу хөвгүүд гэр орон эцэг эхээсээ салан хагацаад модонд авирах, модны ойролцоо унтах, модон дээрх шувуунаас амьтдын хэл мэддэг хүү “шинэ” зүйл сонсож хүүгийн амьдрал өөрчлөгдсөн байх юм.

“Хааны хүү Гомбо, харцын хүү Гонгор” үлгэрт “...хоёр хүү модны сүүдэрт хэвтээд унтаж байтал хоёр хэрээ ирээд энэ зүүнтээ долоон чөтгөр эрдэнийн таяг булаацалдаад хэн нь ч авч чадахгүй байна гэж ярилцахыг сонсоод уран арга сүвэгчилж, эрдэнийн таяг, далдын хар малгай, эрдэнийн шаахай олж авснаар мод нь хүүхдүүдийн зам мөрийг заагч чигчлүүлэгчийн утгыг илэрхийлж байна.” (Жигмэдсүрэн.С., 2013, хууд. 147) Харин эсрэг дүр болох хорлогч чөтгөр, эрлэгийн элчийг эрэгний мухар улаан бут, бургаснаас айдгаар дүрсэлсэн нь устгах сүйрүүлэхийн утгаар дүрслэгджээ.

Монголчууд эрт үеэс модыг сүнстэй, амь холбоотой гэж үздэг байснаар барахгүй эртнээс голлон шүтэж байсан нь саглагар мод /хайлаас/ ба уд мод /бургас/ болно. (Сампилдэндэв.Х., 2004) гэж үзэж ирсэн нь монгол домог зүйд тусгалаа олсон байна.

Монгол домог зүйд долоон хувхай улиас мод нь сайн цагийн мянган бурхан дэлгэрэхийн эх үндэс болон дүрслэгдсэн байдаг [Сайн цагийн мянган бурхан] (Цэрэнсодном.Д., 2010, хууд. 255) нь мод бол уржиж өсөхийн утгыг илэрхийлэх ажээ.

Монголчуудын дунд янз бүрийн мод ургамлыг далдын ид шидтэйд тооцож, эзэд онгодтой болгож, үзэхийн хамт хүн малд тохирох муу юм, саад тотгорыг зайлуулах, тэрчлэн өвчин эмгэгээс хамгаалах онго хэлбэрээр зүүж хэрэглэх ёс байв. (Бадамхатан.С., 1987, хууд. 382) “Хургачин Төмөр” үлгэрт Төмөр хүү барс унан давхиж явах бөгөөд замд нь *өндөр гэгч нь аргагүй хоёр сайхан зандан мод дайралджээ. Хүү ч “Энэ модны аль нэгэнд нь ойр гардаг л юм бол түүнд асаж үлдье” гэж бодоод явтал яг нэг модны дэргэдүүр гарч мань эр ч зандан модыг тэврэн автал уг мод үндсээрээ булгарч гарт нь ирэв.*” (Жигмэдсүрэн.С., 2013, хууд. 117) гэсэн өгүүлэмж нь саад тотгорыг зайлуулах, модны урган төлжихийн бэлгэдлээр хүүгийн өсч хөгжихийн утгыг илэрхийлжээ.

Монголчууд баганыг эрхэмлэхдээ онгон шүтээн мэтээр ойлгон түүнийг алдлах, тэврэх, түшиж зогсохыг цээрлэдэг нь мод шүтэх нэг ёсны хэлбэр юм. Монголд өргөн тархсан нөхөрлөлийн тухай үлгэрт бамбар, тугал хоёр дотно үерхэж яваад тугалыг нь чоно идчихсэнд бамбар хойноос нь харуусан яваад үхэхэд хоёулангийнх нь ясыг нь булсан газраас хоёр сайхан саглагар мод ургаж, ургах нарнаар тэндээс хоёр хөөрхөн хүү гарч Алтан хүү, Мөнгөн хүү нэрийг олон элдэв

саад бэрхшээлийг даван насан туршдаа үерхсэн гэж гардаг нь эх мод шүтэх үзэлтэй холбоотой домог үлгэрийн ойлголт юм.

Эртний хүмүүс овог, гал голомт тус бүрдээ шүтээн модтой байсан бөгөөд хувь заяагаа түүнээс хамааралтай гэж үздэг байв. Халхчуудын ихээхэн эрхэмлэдэг модны нэг бол бургас юм. Бургасыг ихэвчлэн *монгол мод* хэмээн нэрийдэж, аль ч нутагт гол ус дагаж бөөн ургасан цагаан бургасанд гар хүрдэггүй, хэдийгээр хугарч унасан байлаа ч төдийлөн авдаггүй байжээ. Бургасыг уул усанд зориулан босгосон овооны орой дээр хатгах ёс маш түгээмэл байжээ. (Бадамхатан.С., 1987, хууд. 382)

Монгол үлгэрт ах дүү гурав хувь заяагаа сорихоор зүг зүгт салж явахдаа тус бүртээ мод босгон, сайн муу яваагаа модоор шинжих ёсыг “Ах дүү гурав” үлгэрээс бид бэлхнээ мэдэх билээ. Энэхүү онцлог шинж монгол туургатны аман зохиолд ч уламжлагдан иржээ. Торгууд ардын “Амин илд” үлгэрт ах дүүс бие биенийхээ амьд мэнд эсэхийг хоёр зул асаагаад “*аль нэг нь унтарвал надад барцад саад учирсны тэмдэг болтугай*” (Катуу.Б., 2002, хууд. 191) гэж үлдээгээд явж буйгаар “мод” хэмээх дүрслэл нь “гал” хэмээх дүрслэлд шилжсэн нь аман зохиолын аман болон хувилбарт шинжтэй болохыг илтгэнэ.

Монгол явган үлгэрт бас нэгэн сонирхолтой өгүүлэмж ажиглагдаж байна. Модны үндэс буюу булгаран унасан модны нүхнээс увдист эд зүйлсийг олж авсан нь өсөж дэвжихийн утгыг илэрхийлж байна. “Номын Баясгалан, Эрдэнийн Баясгалан” үлгэрт *ах дүү хоёр уулаар явж мод түлээ бэлтгэдэг байв. Нэгэн өдөр тэр хоёр нэг модыг авах гэж оролдоод чадалгүй иржээ. Маргаааш нь хоёр хүү аавынхаа хамтаар өнөөх модыг суга татаж автал модны цаана харанхуй их нүх байв. Тэр нүхнээс “Эрдэнийн ногоон толгойтой тахиа” гаргаж иржээ. Тархийг идсэн хүн хаан болж, голт зүрхийг нь идсэн хүн түшмэл болдог юм гэжээ. Эрдэнийн Баясгалан тархийг нь идээд, ахдаа голт зүрхийг нь идүүлжээ”* (Жигмэдсүрэн.С., 2013, хууд. 37) гэсэн өгүүлэмжээр хоёр хүүгийн өсөж дэвжихийн бэлгэдлийн утгыг дүрслэн үзүүлсэн байна.

Дүгнэлт

Мод нь үндэс, их бие, иш, мөчир болон навч гэсэн дөрвөн гол зүйлээс бүрддэг бөгөөд жил хэмээх цаг хугацааг заасан үгийг агар зандан модоор; модны салаа, мөчрөөр, сар, өдөр, хоногийг; модны навчаар, өдөр, шөнийг тус тус зүйрлэж буй нь модны үндсэн шинж болох олон зуун жилийн настай ургаж төлжих шинж нь цаг хугацааг заан нэрлэж, цаг хугацаа тасралтгүй мөнх үргэлжлэх шинжтэй болохыг илэрхийлж байна.

Бичгийн хэрэгслээс *бийр, бэх, харандаа*, эд юмсын нэрлэлт болох *сам, шүүр* зэрэг оньсогод модны хатуу төлөв байдал, шинж чанарыг зүйрлэхүүн болгож, эд юмс, эдлэл хэрэгслийн тухай оньсогыг бүтээсэн байх юм.

Мод гэсэн зүйрлэхүүн бүхий хэлний баримтыг ажиглахад цаг хугацаа, лусын амьтад, бичгийн хэрэгслийн нэрс, модоор бүтсэн эд юмс, эд эрхтний хөдөлгөөнт эрхтнийг зүйрлэсэн явдал ажиглагдаж буй нь модны шинж болох бүдүүн, хатуу, иш, үндэс, салаа, мөчир гэсэн орны утгын хүрэнээс, шинж чанар, дүр байдал заасан үгсийн хүрээнд зүйрлэхүүний далд мөн чанараар эд юмсыг нэрлэх тохиолдол байдаг ажээ.

Хүүрнэн өгүүлэх аман зохиолын төрөлд модны үндсэн шинж болох ургаж, төлжих, байгаль экологийн чухал ач холбогдолтой эерэг үнэлэмж, хандлага нь шидэт үлгэрт байнга давтагдаад байгаа өгүүлэмжийн хүрээнд *зам мөрийг чиглүүлэгч, үржиж өсөхийн бэлгэдэл, амьдрал тэтгэгч, модыг шүтэх, модоор шинжих* гэсэн утгатай дүрслэлээс мод хэмээх зүйрлэхүүний дүрийн орчныг тодорхойлж буйгаараа ач холбогдолтой болно.

Simile and meaning sentences relating to "tree"

Byambatsetseg Chuluun 

Ph.D, Department of Mongolian Language, Mongolian National University of Education,
Ulaanbaatar, Mongolia

Abstract

When looking at the linguistic evidence for the metaphor "tree", there are cases where it is used to compare time, creatures and animals, writing instruments, and objects and organs made of wood. A tree consists of a stem, roots, branches, and twigs, and there are cases where objects are named by their hidden nature, as metaphors within the context of words that indicate their characteristics and appearance.

In the genre of oral storytelling, the positive value and attitude of the main characteristics of trees, such as growth and reproduction, and the importance of nature and ecology, are often repeated in magical tales as "guides", "symbols of growth", "sustainers of life", "worship of trees" and "analyzing through trees" define the environment of the metaphorical character of a tree.

Keywords: simile of time, simile of animals, stationery, objects, names of organs, semantics, fear of bed

НОМ ЗҮЙ

Бадамдорж.Д. (1997). *Орчин цагийн монгол хэлний утга судлалын үндэс*. Улаанбаатар: Хэвлэлийн газар.

Бадамхатан.С.,. (1987). *БНМАУ-ын угсаатны зүй. Халх угсаатны зүй*. Улаанбаатар: Хэвлэлийн газар.

Дулам.С. (1989). *Монгол домог зүйн дүр*. Улаанбаатар: Хэвлэлийн газар.

Жигмэдсүрэн.С. (2013). *Монгол ардын үлгэр-II*. Улаанбаатар: Хэвлэлийн газар.

Катуу.Б. (2002). *Торгууд ардын аман зохиол*. Улаанбаатар: Хэвлэлийн газар.

Төмөрцэрэн.Ж. (2001). *Монгол хэлний үгийн сангийн судлал*. Улаанбаатар: Хэвлэлийн газар.

Цэрэнсодном.Д. (2010). *Монгол ардын домог үлгэр*. Улаанбаатар: Хэвлэлийн газар.

Цэрэнчимэд.Л. (2024). БУРИАД АЯЛГУУНЫ «ТООНОРХОХО» ХЭМЭЭХ ХЭЛЦ ҮГИЙН УТГА, СОЁЛЫН ОНЦЛОГ. *Бурятский язык и литература в школе*, 23-31. <https://doi.org/10.18101/3033-1310-2024-2-23-31>

Эрдэнэтуяа.П. (2022). Comparative analysis of the concept of "child" in Mongolian and Korean expressions. *Cogent Arts & Humanities*. <https://doi.org/10.1080/23311983.2022.2128582>